



МЭДЭЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

ДУГААР 12



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

1.2
CAP

2024.02.30 - Дугаар/12/



хэсэг боловсруулж, танилцуулан гишүүд хэлэлцэн баталлаа.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХУРАЛДААН БОЛЛОО

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн сургалтын хөтөлбөрийн хорооны 2024 оны эхний хурал 1 дүгээр сарын 8-ны өдөр болж өнгөрлөө.

Хуралдаанаар 2024 онд зохион байгуулах шүүгчийн сургалтын хөтөлбөрийн сэдвүүдийг шүүгчдийн сургалтын хэрэгцээ шаардлагын тандан судалгаанд үндэслэн үндсэн хууль, шүүгчийн ёс зүй, эрүү, иргэн, захиргааны эрх зүйн чиглэл тус бүрээр байгуулагдсан ажлын


“МЕНТОРШИП-2024” ХӨТӨЛБӨР ЭХЭЛЛЭЭ

Шинээр томилогдсон болон залуу шүүгчийг хөгжүүлэх зорилготой “менторшип-2024” хөтөлбөрийн нээлтийн танилцуулга уулзалт 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр шүүгчийн сургалтын цахим системийн вебинар уулзалтаар зохион байгуулагдлаа.

Менторшип хөтөлбөр мэргэжлийн туршлага, ур чадвартай шүүгч өөрийн мэдлэг, туршлагаа шинээр томилогдсон шүүгчтэй хуваалцан, шинэ шүүгчийн мэдлэг чадварыг бэхжүүлэх, хуульд заасан бүрэн эрхээ мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, шинэ шүүгчид биечлэн суралцах боломж олгодгоороо онцлогтой юм. Энэ жилийн “Менторшип-2024” хөтөлбөрт 6 ментор шүүгч, 11 менти шүүгч хамрагдаж байна. Хөтөлбөр зургаан сарын хугацаанд үргэлжилнэ.



ЯПОН УЛСЫН НАГОЯ ИХ СУРГУУЛИЙН АЗИЙН ЭРХ ЗҮЙН СОЛИЛЦООНЫ ТӨВТЭЙ САНАМЖ БИЧИГ



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Япон Улсын Нагоя их сургуулийн Азийн эрх зүйн солилцооны төв (CALE)-тэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

Санамж бичгийн хүрээнд Монгол Улсын шүүхийн шүүгч, шүүхийн алба хаагчдад зориулсан хууль, эрх зүйн онол, практикийн мэдлэг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, судалгааны ажлын хүрээнд айлчлал хийх боломж, нөхцөлийг бүрдүүлэн ажиллахаар болов. Түүнчлэн хамтарсан судалгаа хийх, судалгааны эх сурвалж, материал цуглуулахад харилцан туслалцахад санал нэгдлээ.



LIKE US ON
FACEBOOK:

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



www.jtrii.mn



LINKED IN:

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН ШҮҮХИЙН АКАДЕМИТАЙ УУЛЗАЛТ ХИЙВ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс (БНСВУ)-ын Хууль зүйн яамны харьяа Шүүхийн Академийн дарга ДР.Нгуен Шуан Тутаи хоёр талын уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Уулзалтын үеэр талууд хоёр байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар харилцан мэдээлэл солилцож, улмаар тохиромжтой чиглэлээр хамтран ажиллах боломжийн талаар хэлэлцэв. Цаашид талууд хамтарсан дугуй ширээний уулзалт, семинар зохион байгуулах, судлаачдыг сургах, сургалт зохион байгуулах, олон нийтэд мэдээлэл дамжуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохирлоо.



СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛОО

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Сургалтын хөтөлбөрийн хорооны ээлжит хуралдаан 2024 оны 2 дугаар сарын 5-ны өдөр боллоо.

Уг хуралдаанаар “Үндсэн хуулийн хэрэглээнд анхаарах асуудал”, “Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны тулгамдсан асуудал”, “Баривчлах ажиллагаа болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний шүүхийн хяналт”, “Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалт” хөтөлбөрийг хэлэлцэн, батлахад санал нэгдлээ.



“МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ” СЭТГҮҮЛИЙН №106 ДАХЬ ДУГААР АНГЛИ ХЭЛ ДЭЭР ХЭВЛЭГДЭН ГАРЛАА

“Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 2023 оны 04 дүгээр улирлын тусгай дугаар (106) англи хэл дээр хэвлэгдэн гарлаа.

Энэхүү дугаарт БНТУ-ын Кокаели Их сургуулийн докторант Б.Досжан, БНТУ-ын Сакарья Их сургуулийн магистрант Ж. Арна нарын “Assessment of Hagia Sophia decree of Turkey” болон Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Батбаярын “Legal analysis of subjective elements of crime in the Mongolian Criminal Code from a comparative legal study” зэрэг судалгааны бүтээлүүд тус тус нийтлэгдэв.

